

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2012 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2013.03.06


Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тайлант жилд Хорооны хуралдаанаар 40 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 4 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг сэргээж, 23 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 6 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 212 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрлөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

/График 1/



Тайлант хугацаанд Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг өмнөх онтой харьцуулбал:

/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацаа		
		2011 он	2012 он	өөрчлөлт
1	Тусгай зөвшөөрлийг сунгасан	19	40	21
2	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	32	23	-9
3	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	19	6	-13
4	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	14	4	-10
5	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	8	2	-6
6	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	195	212	17

ББСБ-уудын нийт тоо болон орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг сүүлийн 7 жилийн байдлаар харуулбал:

/Хүснэгт 2/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ
1	2006 он	139	-	-	-
2	2007 он	137	-	-	-
3	2008 он	132	23	11	-
4	2009 он	177	27	9	47

5	2010 он	182	26	15	48
6	2011 он	195	23	17	39
7	2012 он	212	24	18	38

ББСБ-уудыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 3/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо		
		2011 оны IV улирал	2012 оны IV улирал	
1	Зээл	153	171	
2	Факторингийн үйлчилгээ	11	12	
3	Төлбөрийн баталгаа гаргах	8	8	
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	-	-	
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	5	
6	Гадаад валютын арилжаа:	Давхар эрхэлдэг	92	94
		Дагнан эрхэлдэг	39	38
7	Итгэлцлийн үйлчилгээ	16	18	
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2	
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	16	18	
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-	
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ ¹ /Венчур хөрөнгө оруулалт/	1	1	

Тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ууд зээлийн болон гадаад валютын арилжааны үйл ажиллагааг голлон эрхэлж бусад үйл ажиллагааг эрхлэхгүй байгаа нь санхүүгийн зах зээл дээр эх үүсвэр дутмаг, санхүүгийн үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэг муугаас эрэлт, хэрэгцээ дутагдалтайг харуулж байна.

2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 212 ББСБ-аас 209 ББСБ тайлангаа ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн хариуг хүргүүлсэн.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Өмнөх оны жилийн эцсийн голлох статистик үзүүлэлтүүдийг 2012 оны жилийн эцсийн тайлант хугацааны байдалтай харуулбал: Үүнд

/Хүснэгт 4/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал	2012 оны IV улирал	Өсөлт +/-, бууралт /-/
1	ББСБ-ын тоо	195	212	17
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	602	599	-3
3	Ажиллагсадын тоо	1,057	1,193	136
4	Салбар нэгжийн тоо	64	69	5
5	Харилцагчдын тоо	192,577	483,015	290,438
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	205,409,535.1	252,053,541.4	46,644,006.3
Банкны салбарт эзлэх хувь		2.19%	2.10%	-0.09%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	119,004,471.9	157,769,345.8	38,764,873.9
Банкны салбарт эзлэх хувь		2.13%	2.24%	0.11%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	138,182,359.6	171,296,659.6	33,114,300.0

¹Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуульд заагдсан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамаарахгүй бөгөөд Хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг баталсан.

Банкны салбарт эзлэх хувь		20.41%	17.38%	-3.03%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	116,519,924.0	139,194,226.2	22,674,302.2
Банкны салбарт эзлэх хувь		44.11%	45.37%	1.26%
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	14,844,608.6	14,111,454.9	-733,153.7
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	33,030,104.9	46,142,177.6	13,112,072.7
	Үүнээс: Богино хугацаат зээл/мянган төгрөгөөр/	18,950,982.3	25,469,545.7	6,518,563.4
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	14,079,122.6	20,672,631.9	6,593,509.3
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	4,369,186.3	7,977,378.4	3,608,192.1
13	Нийт орлого /мянган төгрөгөөр/	46,348,113.1	116,157,189.5	69,809,076.4
14	Нийт зардал /мянган төгрөгөөр/	34,966,902.5	51,903,731.8	16,936,829.3
15	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	11,381,210.6	18,579,379.1	7,198,168.5

ББСБ-ын нийт актив өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд тайлант үеийн ашиг 7.2 тэрбум төгрөгөөр, дүрмийн сан 22.7 тэрбум төгрөгөөр буюу тухайлвал тайлан жилд шинээр тусгай зөвшөөрөл авсан 23 ББСБ-ын нийт дүрмийн сан 7.7 тэрбум төгрөг, өмнө нь тусгай зөвшөөрөлтэй байсан 55 ББСБ-ууд нийт 15.0 тэрбум төгрөгөөр дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулсан буюу дүрмийн сангийн хэмжээг мөнгөн болон хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн.

Мөн дээрх өсөлтөд тайлант хугацаанд нийт 16.7 тэрбум төгрөгийн төсөл болон банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэр нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд нийт 5 салбар, нэгж шинээр байгуулагдаж, 2 салбар хүчингүй болсон, 23 ББСБ шинээр байгуулагдаж, 6 ББСБ-ын тусгай зөвшөөрөл хүчингүй болсноор ББСБ-д ажиллах боловсон хүчний тоо 136, харилцагчдын тоо 290,438-аар тус тус нэмэгдсэн байна.

2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй 212 ББСБ байгаагийн 88.7 хувь буюу 188 ББСБ нь УБ хотод, 11.3 хувь буюу 24 ББСБ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын байршлыг графикаар үзүүлбэл:

/график 2/



2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2012 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт төвтэй 24 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.3 хувийг, тэдгээрийн актив нь нийт ББСБ-ын активын 2.5 хувийг, олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 3.0 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 3.3 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 3.2 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

/Хүснэгт 5/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал	2012 оны IV улирал	Өсөлт /+/, бууралт /-/
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	23	24	1
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	11.79%	11.32%	-0.47%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	4,791,024.0	6,254,321.4	1,463,297.4
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2.33%	2.48%	0.15%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	3,714,051.5	4,802,425.5	1,088,374.0
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	3.12%	3.04%	-0.08%
	Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	380,629.7	111,512.1	-269,117.60
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	4,606,967.3	5,655,029.6	1,048,062.3
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	3.33%	3.30%	-0.03%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	3,428,621.6	4,434,871.2	1,006,249.6
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	2.94%	3.19%	0.25%
Д	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	60,000.0	164,555.6	104,555.60
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	-	-	-
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	60,000.0	164,555.6	104,555.60
Е	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	63,333.0	134,999.7	71,666.70
Ё	Нийт орлого /мянган төгрөгөөр/	-	1,429,326.0	-
Ж	Нийт зардал /мянган төгрөгөөр/	-	665,603.05	-
З	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	-	763,722.9	-

Хорооноос орон нутагт бичил санхүүгийн тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулах ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг ялгавартай тогтоосон хэдий ч дорвитой өсөлт гарахгүй байгаа нь орон нутагт бичил санхүүгийн үйлчилгээний ач тусын талаар ойлголт муу буюу санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээлэл, сурталчилгаа байхгүй байгаатай холбоотой байна.

2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2012 оны жилийн эцсийн байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 18 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.5 хувийг, тэдгээрийн актив ББСБ-ын нийт активын 17.6 хувийг, олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 18.6 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 17.3 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 17.2 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 6/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал	2012 оны IV улирал	Өсөлт /+/, бууралт /-/
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	17	18	+1
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	8.72%	8.49%	-0.23%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	35,443,995.8	44,357,733.6	8,913,737.8
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	17.26%	17.60%	0.34%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	21,026,423.8	29,287,989.7	8,261,565.9
	Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	1,511,669.2	2,077,091.0	565,421.80
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	17.67%	18.56%	0.89%
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	22,249,301.9	29,658,596.3	7,409,294.4

ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		16.10%	17.31%	1.21%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	18,921,432.5	23,698,562.5	4,777,130.0
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		16.24%	17.19%	0.95%
Д	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	11,005,638.0	9,981,488.9	-1,024,149.10
	Үүнээс: Богино хугацаат зээл /мянган төгрөгөөр/	6,806,572.2	6,260,651.1	-545,921.10
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	4,199,065.7	3,720,837.8	-478,227.90
Е	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	86,833.0	248,890.6	162,057.60
Ё	Нийт орлого /мянган төгрөгөөр/	-	11,078,371.0	-
Ж	Нийт зардал /мянган төгрөгөөр/	-	9,233,42.6	-
З	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	-	1,845,328.4	-

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, Итали, ОХУ, АНУ, БНХАУ-ын хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хууль батлагдсанаар ББСБ-ын салбарт гадны хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжийг хаасан.

2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг эрхлэн явуулж буй ББСБ:

Тайлант хугацаанд буюу 2012 онд нийт 23 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосноос 21.7 хувь буюу 5 ББСБ-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 212 ББСБ байгаагийн 94 ББСБ буюу 44.3 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагийн дотор 38 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 38 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 17.9 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 3.2 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 4.4 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.4 хувийг тус тус эзэлж байна.

/Хүснэгт 7/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал	2012 оны IV улирал	Өсөлт /+/, бууралт /-/
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	39	38	-1
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		20.00%	17.92%	-2.08%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	6,506,229.5	8,105,754.72	1,599,525.22
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		3.17%	3.21%	0.04%
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	6,461,257.6	7,547,276.99	1,086,019.39
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		4.68%	4.40%	-0.28%
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	5,299,942.4	6,281,692.37	981,750.0
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		4.55%	4.51%	-0.04%
Г	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	11,005,638.00	9,981,488.90	-1,024,149.10
Д	Нийт орлого /мянган төгрөгөөр/	-	8,688,029.3	-
Е	Нийт зардал /мянган төгрөгөөр/	-	8,136,914.4	-
Ё	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	-	551,114.9	-

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

/график 3/



3.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант жилд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 8/


№	ХӨРӨНГӨ	2011.12.31		2012.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	197,694,120.3	96.2%	242,772,323.2	96.3%	45,078,202.90	22.8%
1	Мөнгөн хөрөнгө	64,219,136.7	31.3%	66,678,881.6	26.4%	2,459,744.90	3.8%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	3,264,637.9	1.6%	2,202,258.2	0.9%	-1,062,379.70	-32.5%
3	Нийт зээл	119,004,471.9	57.9%	157,769,345.8	62.6%	38,764,873.90	32.6%
	(Зээлийн эрсдлийн сан)	3,791,987.3	1.8%	4,459,428.6	1.8%	667,441.30	17.6%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	673,590.4	0.3%	547.8	0.0%	-673,042.60	-99.9%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	-	-	-	-	-	-
5	Нийт факторингийн тооцооны авлага	2,987,315.0	1.5%	843,620.0	0.3%	-2,143,695.00	-71.8%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	-	-	-	-	-	-
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	552,657.3	0.3%	919,838.1	0.4%	367,180.80	66.4%
7	Бусад хөрөнгө	6,734,825.4	3.3%	18,817,260.2	7.5%	12,082,434.80	179.4%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	4,049,473.0	2.0%	-	-	-4,049,473.00	-100.0%
B	Эргэлтийн бус хөрөнгө	7,715,414.8	3.8%	9,281,218.2	3.7%	1,565,803.40	20.3%
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	7,715,414.8	3.8%	9,281,218.2	3.7%	1,565,803.40	20.3%
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	9,770,929.3	4.8%	12,062,833.0	4.8%	2,291,903.70	23.5%
	(Хуримтлагдсан элэгдэл)	2,055,514.5	1.0%	2,781,614.8	1.1%	726,100.30	35.3%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		205,409,535.1	100.0%	252,053,541.4	100.0%	46,644,006.30	22.7%

ББСБ-ын 2012 оны нийт актив өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар өсөхөд нийт өр төлбөр, дүрмийн сан /хувьцаат капитал/, хуримтлагдсан ашгийн өсөлтүүд гол нөлөөг үзүүлсэн байна.

Тайлант хугацаанд нийт активын 62.6 хувь нь зээл, 26.4 хувь нь мөнгөн хөрөнгө байгаа нь нийт активын 89.0 хувийг эзэлж байна.


ББСБ-уудын нийт активын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 4/



2012 оны нийт активын бүтцийг диаграмаар харуулвал:

/График 5/



3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 9/

№	Ангилал	2011.12.31		2012.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	111,368,770.4	93.6%	147,077,072.0	93.2%	35,708,301.6	32.1%
2	Хугацаа хэтэрсэн	1,509,662.1	1.3%	4,224,854.5	2.7%	2,715,192.4	179.9
3	Чанаргүй зээл. Үүнээс	6,126,039.4	5.1%	6,467,419.3	4.1%	341,379.9	5.6%
	Хэвийн бус	1,809,571.2	1.5%	2,063,839.7	1.3%	254,268.5	14.1%
	Эргэлзээтэй	1,238,029.1	1.0%	1,383,893.7	0.9%	145,864.6	11.8%
	Муу	3,078,439.1	2.6%	3,019,685.8	1.9%	- 58,753.3	-1.9%
	(Зээлийн эрсдлийн сан)	3,791,987.3	3.2%	4,459,428.5	2.8%	667,441.2	17.6%
	Нийт зээл	119,004,471.9	100 %	157,769,345.8	100.0%	38,764,873.9	32.6%


2012 оны жилийн эцсийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 32.6 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 32.1 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 1.8 дахин, чанаргүй зээл 5.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Харин нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар буурсан байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 38,764,873.9 мянган төгрөгөөр буюу 32.6 хувиар нэмэгдсэн хэдий боловч зээлийн чанарт төдийлөн ахиц гараагүй байна гэж үзэж байна. Тухайлбал, тайлант онд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад муу зээлийн хэмжээ 58,753.3 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурч харин хэвийн, хэвийн бус, эргэлзээтэй зээлийн хэмжээ 11.8-32.1 хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 2,715,192.4 мянган төгрөгөөр буюу 1.7 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал:

/График 6/



/График 7/



Графикаас харахад нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2009 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан бол тайлант 2012 оны жилийн эцсийн байдлаар 2009 оны мөн үеэс 2.1 дахин буурсан үзүүлэлттэй байна.

3.3 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 212 ББСБ-аас 80.7 хувь буюу 171 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 8.0 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

Арифметик энгийн дунджаар тооцож үзвэл ББСБ-уудын зээлийн сарын дундаж дээд хүү 3.8 хувь, зээлийн дундаж доод хүү 2.1 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 2.9 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

/График 8/



ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-уудын 2012 оны тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх онтой харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 10/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2011.12.31		2012.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Өр төлбөр	54,217,683.3	26.4%	70,863,151.70	28.1%	16,645,468.40	30.7%
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	14,844,608.6	7.2%	14,111,454.94	5.6%	-733,153.66	-4.9%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	33,030,104.9	16.1%	46,142,177.59	18.3%	13,112,072.69	39.7%
3	Бусад эх үүсвэр	1,973,783.5	1.0%	2,547,535.80	1.0%	573,752.30	29.1%
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	-	-	300.00	-	300.00	100%
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	1,973,783.5	1.0%	2,547,235.80	1.0%	573,452.30	29.1%
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	-	-	-	-	-	-
	Факторингийн үйлчилгээний өглөг	-	-	-	-	-	-
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	-	-	-
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	-	-	84,605.00	-	84,605.00	100.0%
5	Төслийн зээлийн санхүүжилт	4,369,186.3	2.1%	7,977,378.37	3.2%	3,608,192.07	82.6%
	Бусад өр төлбөр	13,009,492.2	6.3%	9,893,730.05	3.9%	- 3,115,762.15	-23.9%

Санхүүгийн зохицуулах хороо

Бичил санхүүгийн газар

6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,095,721.8	1.0%	2,300,211.41	0.9%	204,489.61	9.8%
7	Бусад пассив	6,868,125.4	3.3%	7,593,518.64	3.0%	725,393.24	10.6%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	4,045,645.0	2.0%	-	-	-4,045,645.00	-100.0%
Нийт өр төлбөр		67,227,175.5	32.7%	80,756,881.75	32.0%	13,529,706.25	20.1%
Б	Эзэмшигчдийн өмч	138,182,359.6	67.3%	171,296,659.61	68.0%	33,114,300.01	24.0%
9	Хувьцаат капитал	116,519,924.0	56.7%	139,194,226.17	55.2%	22,674,302.17	19.4%
10	Бусад өмч	3,189,400.2	1.6%	6,259,932.97	2.5%	3,070,532.77	96.3%
11	Сангууд	1,122,754.7	0.5%	108,830.83	0.0%	-1,013,923.87	-90.3%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	14,681,605.6	7.1%	24,165,469.86	9.6%	9,483,864.26	64.6%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	2,668,675.1	1.3%	1,568,199.78	0.6%	-1,100,475.32	-41.2%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		205,409,535.1	100%	252,053,541.36	100.0%	46,644,006.26	22.7%

2011 оны жилийн эцсийн тайлангаар нийт эх үүсвэрийн 32.7 хувийг нийт өр төлбөр, 67.3 хувийг эзэмшигчдийн өмч эзэлж байсан бол 2012 оны жилийн эцэст нийт өр төлбөр 32.0 хувь, эзэмшигчдийн өмч 68.0 хувь болж өөрчлөгдсөн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 20.1 хувиар, эзэмшигчдийн өмч 24.0 хувиар тус тус өссөн байна.


2012 онд нийт эх үүсвэрт эзлэх өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 46,142,177.6 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 39.7 хувиар буюу 13,112,072.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.


Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр дүрмийн сан өсч байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 9/



/График 10/



2012 оны жилийн эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 18 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.5 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 37.5 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 34.4 хувийг тус тус эзэлж байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 ББСБ нь нийтдээ 929.7 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын гүйлгээг 40,281 удаагийн баримтын эргэлтээр гуйвуулж, 2012 оны жилийн эцэст нийтдээ 2,547,235.8 мянган төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй байна.

2012 оны жилийн эцсийн байдлаар хоёрдогч өглөгтэй 6 ББСБ-д нийтдээ 1,568,199.8 мянган төгрөгийн хоёрдогч өглөг бүртгэлтэй байна.

Хорооны 2010 оны 199 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам”-ыг батлан мөрдөж эхэлсэн ба энэхүү журмыг 2012 оны 248 дугаар тогтоолоор хүчингүй болгож “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичиг бүртгэх журам”-ыг шинэчлэн баталж, мөн оны 346 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.

Хаалттай өрийн бичгийн зөвшөөрөлтэй 2 ББСБ-д нийт 1,400.0 мянган төгрөгийн өрийн бичиг гаргахаар Хороонд бүртгүүлсэн боловч 2012 оны жилийн эцсийн байдлаар нийт 84.6 мянган төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргаад байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-уудын 2012 оны жилийн эцсийн байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 11/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.12.31		2012.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	30,331,494.1	65.4	45,674,078.7	39.3	15,342,584.6	50.6
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	28,066,043.2	60.6	43,343,624.9	37.3	15,277,581.7	54.4
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	662,009.6	1.4	1,252,387.4	1.1	590,377.8	89.2
	Үнэт цаасны хүүгийн орлого	-	-	-	-	-	-
	Бусад хүүгийн орлого	1,603,441.2	3.5	1,078,066.4	0.9	-525,374.8	-32.8
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	15,233,947.4	32.9	23,344,791.3	20.1	8,110,843.8	53.2
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	776,368.3	1.7	1,149,374.9	1.0	373,006.6	48.0
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	6,303.3	0.0	314,865.9	0.3	308,562.6	48.9 дахин

	НИЙТ ОРЛОГО	46,348,113.1	100.0	70,483,110.8	100.0	24,134,997.7	52.1
--	--------------------	---------------------	--------------	---------------------	--------------	---------------------	-------------

Тайлант хугацааны нийт орлогын 39.3 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 50.6 хувиар өссөн/, 20.1 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 53.2 хувиар өссөн/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 53.2 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 12/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.12.31		2012.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Арилжааны орлого	5,848,252.0	38.4	12,339,548.1	52.9	6,491,296.1	111.0
1.1	Гадаад валютын арилжааны орлого	5,205,557.5	34.2	10,975,889.7	47.0	5,770,332.2	110.8
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	642,694.6	4.2	1,363,658.4	5.8	720,963.8	112.2
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	6,577,226.0	43.2	7,016,892.9	30.1	439,666.9	6.7
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	6,555,132.3	43.0	6,100,891.7	26.1	-454,240.6	-6.9
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	22,093.7	0.1	916,001.1	3.9	893,907.4	40.5 дахин
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	2,808,469.4	18.4	3,988,350.3	17.1	1,179,880.9	42.0
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	6,890.6	0.0	2,235.0	0.0	-4,655.6	-67.6
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	2,032.1	0.0	2,440.1	0.0	408.0	20.1
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	738,727.2	4.8	815,196.9	3.5	76,469.7	10.4
3.4	Картын үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	91,555.4	0.6	110,691.4	0.5	19,136.0	20.9
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,425,885.4	9.4	2,166,701.7	9.3	740,816.3	52.0
3.7	Бусад	543,378.7	3.6	891,085.1	3.8	347,706.4	64.0
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	15,233,947.4	100.0	23,344,791.3	100.0	8,110,843.9	53.2

2011 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 34.2 хувийг гадаад валютын арилжааны орлого, 43.2 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 18.4 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2012 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 47.0 хувийг гадаад валютын арилжааны орлого, 30.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 17.1 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 13/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.12.31		2012.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	5,098,832.7	14.6	6,544,599.3	12.6	1,445,766.6	28.4
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	25,603,893.3	73.2	39,542,613.1	76.2	13,938,719.8	54.4
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	2,114,666.7	6.0	2,322,916.0	4.5	208,249.3	9.8
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	636,885.0	1.8	1,016,701.4	2.0	379,816.4	59.6
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	17,828.4	0.1	13,738.3	0.0	-4,090.1	-22.9
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	1,494,796.4	4.3	2,463,163.7	4.7	968,367.3	64.8

	НИЙТ ЗАРДАЛ	34,966,902.5	100.0	51,903,731.8	100.0	16,936,829.3	48.4
--	--------------------	---------------------	--------------	---------------------	--------------	---------------------	-------------

2012 оны жилийн эцсийн байдлаар нийт зардал өмнөх оны мөн үеэс 48.4 хувиар өссөнөөс хүүгийн зардал 28.4 хувиар, хүүгийн бус зардал 54.4 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 9.8 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 59.6 хувиар, орлогын татварын зардал 64.8 хувиар тус тус өсч, ердийн бус зардал 22.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын 2012 оны жилийн эцсийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар, нийт зардал 48.4 хувиар тус тус өссөн байна.

2012 оны жилийн эцсийн байдлаар нийт 18,579,379.1 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 63.2 хувиар өссөн байна.

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 14/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.12.31	2012.12.31	Өөрчлөлт
		Дүн	Дүн	Дүн
1	НИЙТ ОРЛОГО	46,348,113.1	70,483,110.8	24,134,997.7
2	НИЙТ ЗАРДАЛ	34,966,902.5	51,903,731.8	16,936,829.3
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	11,381,210.6	18,579,379.1	7,198,168.5

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 11/



Өмнөх онтой харьцуулахад системийн хувьд нийт ашиг нэмэгдсэн мөн ББСБ-уудын активын болон тооны өсөлт, тэдгээрийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдсэн байна.

Тайлант жилд 187 ББСБ буюу нийт ББСБ-ын 88.2 хувь нь ашигтай ажиллаж тэдгээрийн нийт ашиг 20,615,517.7 мянган төгрөгт хүрсэн байна.

ЗУРГАА. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай 400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 1,000,000.0 мянган төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай ББСБ гэсэн 3 бүлэгт хуваан тооцов.

2012 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 15/

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мянган төгрөг/	Нийт активт эзлэх хэмжээ /хувь/	
1	Бүлэг 01	45	185,150,832.7	73.5%	1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний активтай
2	Бүлэг 02	107	58,040,050.5	23.0%	400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
3	Бүлэг 03	60	8,862,658.2	3.5%	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
НИЙТ		212	252,053,541.4	100.0%	

2012 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн тайлант үеийн ашиг дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

/Хүснэгт 16/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Нийт актив	Дүрмийн сан	Ашиг	Салбарын нийт татварын дараах цэвэр ашигт эзлэх хувь
1	Бүлэг 01	185,150,832.7	82,650,527.1	14,444,710.3	77.7%
2	Бүлэг 02	58,040,050.5	47,532,065.7	3,840,027.6	20.7%
3	Бүлэг 03	8,862,658.2	7,691,633.4	294,641.2	1.6%
НИЙТ		252,053,541.4	137,874,226.2	18,579,379.1	100.0%

Бүлгүүдийн актив, ашгийн үзүүлэлтүүдийг харахад “Бүлэг 01”-д хамаарах ББСБ –ууд нь нийт ББСБ-ын 21.2 хувийг эзэлж байна.

ДОЛОО. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант улирлын байдлаар Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 173 ББСБ бүрэн хангаж ажилласан, 39 ББСБ 1-3 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй үзүүлэлттэй байгаагаас 1 харьцааг хангаж ажиллаагүй 18 ББСБ, 2 харьцааг хангаж ажиллаагүй 19 ББСБ, 3 харьцааг хангаж ажиллаагүй 2 ББСБ байна.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 171,210,710.5 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 183,956,191.0 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 91.9 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 93.1 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 67.1 хувь;

- түргэн борлогдох актив 57,486,994.8 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 55,576,323.9 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 103.4 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 4,189,110.1 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 171,210,710.5 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 2.45 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 14,111,454.9 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 171,296,659.6 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 8.2 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 2,788,919.1 мянган төгрөг, нийт актив 252,053,541.4 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.1 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 4,606,277.8 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 47,713.1 мянган төгрөгөөр илүү буюу нийт 4,653,990.9 мянган төгрөгөөр байгуулсан байна.²

НАЙМ. ДҮГНЭЛТ

1. Тайлант жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 212 ББСБ-аас 209 ББСБ /98.6 хувь/ тайлангаа ирүүлсэн ба 6 ББСБ /2.8 хувь/ эхлэлтийн санхүүгийн балансаар болон өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс тайлангийн ирц сайжирсан байна.
2. Нийт 29 ББСБ нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлүүдээс 3-4 төрлийн үйл ажиллагааг зэрэг эрхлэхээр тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа ч ББСБ-уудын хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө санхүүгийн чадвараас хамаарч үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх хандлага сул байна.
3. ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 46,644,006.3 мянган төгрөг буюу 22.7 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 38,764,873.9 мянган төгрөг буюу 32.6 хувь, эзэмшигчдийн өмч 33,114,300.0 мянган төгрөг буюу 24.0 хувь, нийт дүрмийн сан 21,354,302.2 мянган төгрөг буюу 18.3 хувиар тус тус өссөн байна.
4. ББСБ-уудын нийт актив 2012 оны жилийн эцсийн байдлаар 252,053,541.4 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын **/банкны салбарын нийт актив 11,992,228,063.4 мянган төгрөг/** 2.1 хувь, зээлийн өрийн үлдэгдэл 157,769,345.8 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн **/банкны салбарын нийт зээл 7,026,247,265.4 мянган төгрөг/** 2.2 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 6,467,419.3 мянган төгрөг байгаа нь банкны салбарын чанаргүй зээлийн **/банкны салбарын чанаргүй зээл 293,295,810.5 мянган төгрөг/** 2.2 хувь, дүрмийн сан 139,194,226.2 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сангийн **/банкны салбарын нийт дүрмийн сан 306,800,631.8 мянган төгрөг/** 45.4 хувьтай тус тус тэнцэж байна.
5. Тайлант жилд 01 дүгээр бүлгийн буюу 1.0 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 45 ББСБ байгаа ба тэдгээрийн нийт актив 185.1 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 6 ББСБ-ын 37.1 тэрбум төгрөгөөр өссөн, 212 ББСБ-ын нийт актив хөрөнгө 252.0 тэрбум төгрөг, нийт зээл цэврээр 153.4 тэрбум төгрөг бөгөөд 64.9 хувь нь орлого оруулдаг актив, актив хөрөнгийн өгөөж 13.2 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 19.2 хувьтай байна.
6. 2012 онд Хороонд төвлөрүүлбэл зохих нийт 195 ББСБ-ын 180,520.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөгдөхөөс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 191 ББСБ-ын 180,260.0 мянган төгрөгийг Хорооны дансанд төвлөрүүлсэн нь 99.8 хувьтай байна.
7. Зээлийн мэдээллийн тухай хууль 2011 оны 10 дугаар 20-ны өдөр батлагдан гарснаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн, байгууллага зээлийн мэдээллийн сантай байхаар хуульчилсны дагуу тайлант жилд нийт 76 ББСБ Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглаж байгаа нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх 171 ББСБ-ын 44.4 хувийг, нийт 212 ББСБ-ын 35.8 хувийг тус тус эзэлж байна.
8. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг газар дээр нь шалгах ажлын хүрээнд 2011 оны IV улирлаас эхлэн газар дээрх хяналт шалгалтын удирдамжид “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийн талаар хэсэг оруулж, 2012 онд нийт 35 ББСБ-д газар дээрх хяналт шалгалтыг хийх явцдаа “Мөнгө угаах болон

²Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн 5.2-д заасны дагуу эцэг /эх/-ийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, цээж зураг зэрэг шаардлагатай мэдээллийг авч байгаа эсэхэд хяналт тавин ажилласан ба нийт 87 ББСБ нь Хорооны 2009 оны 253 дугаар тогтоолоор батлагдсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээ мэдээлэх журам”-ын дагуу хуулийн хэрэгжилтийг хариуцсан байнгын хяналт тавих ажилтныг томилон, шийдвэрийг Хороонд ирүүлсэн байна.

9. Нийт 18 ББСБ нь Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулах хуулийн хариуцлагатайгаас 97.7 хувь буюу 177 ББСБ санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулан Хороонд ирүүлсэн бөгөөд 156 ББСБ нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.4-д “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан, 25 ББСБ хуулийг хэрэгжүүлээгүй байна.
10. Бичил санхүүгийн хөгжлийн сангаас дамжуулан зээлдүүлэх сонгон шалгаруулалтад 11 ББСБ нь тэнцсэн бөгөөд нийт 4,710.0 сая төгрөгийн зээлийн гэрээ хийснээс тайлант жилийн эцсийн байдлаар 2,496.0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.

ЁС. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛБЭЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭ

2013 онд дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

1. ББСБ-уудаас хүлээн авах санхүүгийн тайлан мэдээ, мэдээллийг цуглуулах мэдээллийн сан, нэгдсэн сүлжээг сайжруулах;
2. Зээл, зээлтэй адилтган тооцох активыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилж хэвшүүлэх;
3. Зээлийн мэдээллийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголбанкны зээлийн мэдээллийн санд холбогдсон ББСБ-уудын тоог нэмэгдүүлэх;
4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах;
5. Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын үйл ажиллагаанд гүйцэтгэх газар дээрх хяналт, шалгалтын ажлыг идэвхижүүлэх;
6. Орон нутгийн төлөөлөгч нартай нягт хамтран ажиллах;
7. Үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, санхүү, төлбөрийн чадварыг тогтворжуулах, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ББСБ-уудын удирдлага, ажилтнуудад зориулсан сургалт, зөвөлгөөг нийслэл болон орон нутагт бүсчлэн зохион байгуулах, сургалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР